



“ДОРНОД БҮСИЙН ЭРЧИМ ХҮЧНИЙ СИСТЕМ”
ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛЭЭС

2021 оны 10 сарын 15 өдөр

Дугаар 06

Хэрлэн сум

“Дорнод бүсийн эрчим хүчний систем” төрийн өмчит хувьцаат компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2021 оны 10 дугаар сарын 15-ны өдрийн 06 дугаар хурлын тэмдэглэлд:

ХЭЛЭЛЦСЭН НЬ:

Компанийн 2021 оны II улирлын санхүүгийн тайлан, техник, эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалт, их засвар, техник зохион байгуулалтын арга хэмжээний гүйцэтгэлийн тухай.

ТЭМДЭГЛЭСЭН НЬ:

Компани 2021 оны II улиралд 262.2 сая төгрөгийн алдагдалтай ажиллахаар төлөвлөсөн ч тайлант хугацаанд компанийн бүтээгдэхүүн үйлдвэрлэл нэмэгдсэн тул 1,247.0 сая төгрөгийн ашигтай ажиллаж, эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшингийн биелэлт 82.3 хувьтай байна.

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

“Компанийн 2021 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалт, их засвар, техник зохион байгуулалтын арга хэмжээний төлөвлөгөөг үзүүлэлт бүрээр ханган биелүүлж ажиллахыг Гүйцэтгэх захирал Г.Отгонбаатарт даалгав” гэжээ.

ДАРГА



Ж.ЖАНАРБААТАР



“ДОРНОД БҮСИЙН ЭРЧИМ ХҮЧНИЙ СИСТЕМ”
ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛЭЭС

2021 оны 10 сарын 15 өдөр

Дугаар 08

Хэрлэн сум

“Дорнод бүсийн эрчим хүчний систем” төрийн өмчит хувьцаат компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2021 оны 10 дугаар сарын 15-ны өдрийн хурлын 08 дугаар тэмдэглэлд:

ХЭЛЭЛЦСЭН НЬ:

Компанийн 2021-2022 оны өвлийн бэлтгэл ажлын төлөвлөгөөний биелэлтийн тухай.

ТЭМДЭГЛЭСЭН НЬ:

Компанийн 2021-2022 оны өвлийн бэлтгэл ажлыг хангах төлөвлөгөөний хүрээнд хөрөнгө оруулалтын ажлын биелэлт 92.3 хувь, их засварын ажлын биелэлт 88.7 хувь, техник зохион байгуулалтын арга хэмжээний биелэлт 88.9 хувь, өвлийн бэлтгэл ажлын гүйцэтгэл дунджаар 89.8 хувьтай байна.

Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахалтай холбоотой улсын хэмжээнд тогтоосон хөл хорио, хил, гаалийн асуудлаас шалтгаалан зуух №2-ын их засвар, Баруун-Урт-Өндөрхаан 110 кВ ЦДАШ-ын тусгаарлагч элемент солих, мазут, давс нөөцлөх зэрэг ажлуудад гэрээний хэрэгжилтийн үед хугацаа сунгах, гэрээ цуцлах, тендер дахин зарлах зэрэг нөхцөл байдлууд тус тус үүссэн байна.

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

“Компанийн 2021-2022 оны өвлийн бэлтгэл ажлын хүрээнд дутуу гүйцэтгэлтэй байгаа дээр дурдсан болон бусад ажлуудыг яаралтай бүрэн дуусгаж, үйлдвэрлэлийн хэвийн, тасралтгүй, найдвартай ажиллагааг хангах, авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаар Төлөөлөн удирдах зөвлөлийн 2021 оны 11 дүгээр сарын ээлжит хуралдаанд танилцуулахыг Гүйцэтгэх захирал Г.Отгонбаатарт үүрэг болгов” гэжээ.

ДАРГА



Ж.ЖАНАРБААТАР



“ДОРНОД БҮСИЙН ЭРЧИМ ХҮЧНИЙ СИСТЕМ”
ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛЭЭС

2021 оны 10 сарын 15 өдөр

Дугаар 07

Хэрлэн сум

“Дорнод бүсийн эрчим хүчний систем” төрийн өмчит хувьцаат компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2021 оны 10 дугаар сарын 15-ны өдрийн хурлын 07 дугаар тэмдэглэлд:

ХЭЛЭЛЦСЭН нь:

Компанийн 2021 оны бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний биелэлтийн тухай.

ТЭМДЭГЛЭСЭН нь:

Тус компани нь 2021 оны бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны ерөнхий төлөвлөгөөгөөр тайлант хугацаанд 105 нэр төрлийн бараа, материал, ажил үйлчилгээг нийт 9,601.9 сая төгрөгөөр худалдан авахаар төлөвлөснөөс 94 нэр төрлийн 7,583.9 сая төгрөгийн худалдан авах ажиллагааг зохион байгуулж, 89.5 хувийн биелэлттэй ажилласан байна.

ШИЙДВЭРЛЭСЭН нь:

“Компанийн 2021 оны бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний дагуу дутуу гүйцэтгэлтэй байгаа бараа, ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааг холбогдох хууль, тогтоомжид нийцүүлэн үр дүнтэй, шуурхай зохион байгуулах, 2022 оны хөрөнгө оруулалт, их засвар, техник зохион байгуулалтын арга хэмжээ болон худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг төслийн үр ашиг, ач холбогдлыг тооцож, зураг төсөвт үндэслэн боловсруулахыг Гүйцэтгэх захирал Г.Отгонбаатарт тус тус даалгав” гэжээ.

ДАРГА



Ж.ЖАНАРБААТАР